



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 4/47

Модот

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нотариатын 2026 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн гэрээг судлан үзээд иргэн Чүлтэм овогтой Нямбаатар (ЖИ70042938)–ийн эзэмшиж буй 2 дугаар баг Нугаар, Чулуутын үзүүрт байрлах, 2321002325 нэгж талбарын дугаартай, өвөлжөөний зориулалттай 10001 квадрат метр газрын эзэмших эрхээс Нугаар их тариат хоршоо (4192176)-д 4697м² газрыг хэсэгчлэн шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар эзэмшил, ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигч Нугаар их тариат хоршооны дарга (Б.Чулуунцэцэг)-д даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Я.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын засаг даргын 2012 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн Б/73 тоот захирамжийн иргэн Ч.Нямбаатар-д холбогдох хэсэг эзэмшлийн 0000277063 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



